

Хөнгөн уншлагын арга

Ш.Нандинцэцэг*, Н.Ариунаа
Мандах Их Сургууль

Хураангуй

Өнөө үед техник технологи хурдацтай хөгжихийн хэрээр оюутан суралцагсад өөрсдийн сурах үйлдээ түүний давуу талыг өргөнөөр ашиглах хандлагатай болж байна. Энэхүү хэрэгцээ шаардлагад тулгуурлан багш нар сургалтдаа техник технологийн дэвшлийг өргөнөөр ашиглаж байна. Бид энэхүү судалгааны ажлаараа Мандах Их Сургуульд хөнгөн уншлагын аргыг Xreading. com цахим номын санг ашиглан хэрэгжүүлж буй туршлагаа хуваалцахыг зорилоо. Хөнгөн уншлагын аргыг нэг жилийн хугацаанд гурван үе шатаар уншигчдын ганцаарчилсан уншлагын хэлбэрээр хэрэгжүүлсэн туршилт судалгааны үр дүнгээр суралцагсад Англиар ном унших сэдэл тэмүүлэлтэй болсон нь харагдаж байна. Үүний зэрэгцээ бид суралцагсдын унших үйл явц, үр дүнг бусад орны суралцагсдын үр дүнтэй харьцуулан танилцуулахаар зорилоо. Цахим номын сангийн тусламжтайгаар Англи хэлээр ном унших нь суралцагсдын сурах арга барилыг өөрчлөх төдийгүй багш бидний хувьд Англи хэл заах арга зүйдээ нэвтрүүлэх олон боломжуудын нэг болохыг бид судалгааны ажлаараа тодрууллаа.

Түлхүүр үг

Хялбаршуулсан ном, цахим номын сан, хэрэгжүүлэлт, унших дадал

Удиртгал

Техник технологийн дэвшил ба гадаад хэлний сургалт: Өнөө үед техник технологийн дэвшил харилцаа холбооны олон арга хэрэгслийг ашиглах боломжийг нээж өгснөөр дэлхий нийтээрээ интернет ашиглаж, англиар харилцах боломж үүд хаалга улам бүр нээгдсээр байна. Дэлхийд нэг тэрбум гаруй хүн англи хэлийг хоёрдогч гадаад хэлээ хэмээн ашигладаг бол 375 сая орчим эх хэлтэн байгаа ба үүнээс гадна дэлхийн олон оронд сонин, ном, сэтгүүл нь англи хэлээр хэвлэгддэг, шинжлэх ухаанд хамгийн ихээр хэрэглэгддэг буюу судлаачдын үзэж байгаагаар шинжлэх ухааны өгүүлүүдийн 95% нь тус хэл дээр бичигдсэн байдгаас зөвхөн тал нь л төрөлх англи хэлтэй зохиогчид байна.

Иймд техник технологийн дэвшил хийгээд англи хэл хоёр хоорондоо харилцан уялдаатай ойлголт гэж үзэж болох ба техник технологи хөгжихийн хирээр англи хэлээ хоёрдогч хэл болгон судалж байгаа хэн бүхэнд хэл сурах хязгааргүй боломж нөхцөлүүдийг бүрдүүлэхийн сацуу дэлхийн аль ч орны хүмүүстэй харилцах, мэдээллийг шуурхай авах, өөрийгөө хөгжүүлэх зэрэг олон давуу талууд бий болж байна.

Технологийн дэвшлийг бид зөвхөн харилцааны хэрэгсэл болгон ашиглахаас гадна олон салбарт тэр дундаа боловсролын салбарт өргөнөөр ашиглаж байгаагийн нэг жишээ нь өнөөдөр олон их дээд сургуулиудад зайн сургалт, цахим онлайн шалгалт, тэр ч бүү хэл цаасан

номын оронд компьютерийн тусламжтай сургалтын хэрэглэгдэхүүнийг олон янзаар ашиглах боломжтой болсон. Дараах зургаар англи хэлний сургалт ба техник технологийн дэвшилд хэл, сургалт, англи хэл гурвын хамаарлыг харуулсан байна.



Зураг 1. Техник технологийн дэвшил ба англи хэлний хамаарал Эх сурвалж: Iowa State University, (Canvas.net, 2018)

Англи хэлний сургалтад гарч буй энэхүү өөрчлөлт чиг хандлага хийгээд техник технологийн хөгжилд багш бид нийцэж, эдгээр олон эх сурвалжийг хэрхэн үр дүнтэй ашиглах, хэрэглэж сурах, суралцагсдын хэрэгцээ сонирхолд нийцүүлэн сургалтын агуулгыг баяжуулах зэрэг өнөөгийн сургалтад нэвтэрч буй шинэлэг арга хэрэгсэлтэй танилцах, сурч мэдэх, ашиглах зайлшгүй хэрэгцээ шаардлагатай тулгарч байна.

Аливаа гадаад хэлний сургалт унших, сонсох, бичих, ярих гэсэн дөрвөн чадвараас гадна үгсийн сан болон хэл зүйн дүрмийн мэдлэг олгоход голлон чиглэгддэг бөгөөд эдгээр мэдлэг,

чадвар бүрийг хөгжүүлэхэд технологит суурилсан орчин үеийн заах арга зүйн шинэлэг олон арга хэрэгслүүд нэвтэрч байгаагийн нэг нь суралцагсдын унших чадвар болон үгсийн сангийн мэдлэгийг хөгжүүлэхэд чиглэгдсэн олон улсад тэргүүн туршлага болсон “Хөнгөн уншлагын арга”-ыг интернет болон ухаалаг утасны тусламжтай ашиглаж, англи хэлний сургалтад хэрхэн нэвтрүүлэх талаар судалсан болно.

Судлагдсан байдал, судалгааны арга зүй

Хөнгөн уншлагын арга нэр томъёог анх Харолд Палмер хоёрдогч хэлийг заахдаа ашигласан бөгөөд тэрээр оюутнууд их зүйлийг хурдан унших нь зүйтэй гэж тодорхойлжээ. (Kelly, 2015) Мөн Майкл Вэст энэхүү аргыг анхлан нээхэд үнэтэй хувь нэмэр оруулж, хөнгөн уншлагын арга зүйг боловсруулсан ба суралцагсдын хичээлээс гадуурх нэмэлт уншлагын арга болохыг томъёолсон байна. (West, 1955) Хөнгөн уншлагын аргыг цаашид Ричард Дэй болон Вампорд нар хөгжүүлсэн бөгөөд тэд энэхүү аргыг амжилттай хэрэгжүүлэх арван зарчмыг боловсруулсан. (Day R. B., 1998)

Өнөөг хүртэл хөнгөн уншлагын аргын талаар 600 гаруй ном, бүтээл гарсан бөгөөд гадаад хэлний сургалтад зорилтот хэлээр ном унших нь хэлний дөрвөн чадварыг зэрэг хөгжүүлэх боломжтой тухай “Үгсийн санг баяжуулах нь” (Chen, 2013), “Унших чадварыг хөгжүүлэх нь” (Mason B., 1997), “Бичгийн чадварыг хөгжүүлэх нь” (Krashen, 2014), “Ярианы чадвар” (Kyung-Sook Cho, 1994) зэрэг бүтээлд тус тус бичсэн байна. Харин Монголд Jet англи хэлний сургалтын төвийн багш Д.Сумъяа энэ аргыг гадаад хэлний сургалтад хэрэгжүүлэх талаар магистрын зэрэг хамгаалсан байна.

Судалгааны арга

Бид Мандах Их Сургуулийн багш оюутнуудад Хөнгөн уншлагын аргыг Xreading.com цахим номын санг ашиглан гурван үе шатаар тоон болон чанарын судалгаа, харьцуулалт, туршилтын аргуудаар англи хэлний сургалтад хэрэгжүүлсэн үр дүнг танилцуулж байна.

1.Extensive reading буюу Хөнгөн уншлагын арга ба Xreading.com цахим номын сан

Унших нь цогц үйл явц бөгөөд зорилтот хэлээр ном их унших нь сурах үйлд илүү тустай болохыг олон судлаачид дүгнэж хэлсэн байдаг. Судалгаагаар ном уншдаг суралцагчийг уншдаггүй суралцагчтай харьцуулахад үгсийн

сангийн болон бичих чадварын хувьд илүү хөгжсөн байдаг гэжээ. (Slatter, 2018) Орчин үед суралцагсдын унших чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн технологит суурилсан олон арга хэрэгслүүд, эх сурвалжууд байгаагаас хөнгөн уншлагын аргыг дэмжсэн, сургалтын зорилгоор дэлхийн олон оронд хэрэгжиж байгаа аргыг цааш тодруулав.

Хөнгөн уншлагын арга нь уншиж сурах зарчимд чиглэгдсэн сургалтын идэвхтэй арга бөгөөд суралцагчийг төрөлх болон зорилтот хэлээр хязгааргүй унших дадалд сургах улмаар ном уншихад дуртай болгоход багшийн зүгээс хөтлөх зорилготой. (Richard, 2015) Хөнгөн уншлагын гол зарчим нь суралцагч өөрт тааламжтай байдлаар уншихын тулд тухайн унших материал суралцагчийн унших түвшинд тохирсон хялбар буюу хуудас тутамд хамгийн багадаа нэгээс хоёр шинэ үг байх ба ерөнхийдөө уншигч нийт үгсийн сангийн 90-с дээш хувийг мэддэг байхыг зөвлөдөг тул уншлагын явцад толь бичиг ашиглах шаардлагагүй гэж үздэг. Мөн түүнчлэн энэхүү аргын өөр нэг зарчим нь суралцагч унших материалаа өөрөө сонгох ба үүнд хэн нэгний шахалт оролцоогүй байна гэж үздэг.

Олон оронд хөнгөн уншлагын аргыг цаасан хэлбэрээр өргөнөөр ашигладаг байсан бол харин өнөө үед техник технологийн дэвшлийг ашиглан ухаалаг утас болон компьютерээсээ хаана, хэзээ ч унших боломжийг бүрдүүлсэн Xreading.com цахим номын санг Квансей Кагюн их сургуулийн багш Паул Голдберг Япон улсад анх 2014 онд зохиосон ба өнөөдөр дэлхийн олон оронд тухайлбал Япон, Өмнөд Солонгос, Тайван, Вьетнам, Гүрж, Хятадад өргөнөөр ашиглаж байна. Тэрээр өөрийн сургалтдаа хөнгөн уншлагын аргыг цаасан хэлбэрээр ашигласан туршлага дээрээ үндэслэн цахим номын санг зохиосноор оюутан суралцагсдын сонирхолд нийцсэн орчин үеийн шинэлэг арга болохыг олж мэдэхийн сацуу олон бэрхшээлтэй тулгарч байсныг дурджээ. Үүнээс уншигчдын сонирхол, түвшинд тохирсон номын хангамж хомс, суралцагсдын хичээлээс гадуурх унших үйл явцыг багшийн зүгээс хянахад гол бэрхшээл тулгарч байсан ба үүнийг шийдвэрлэх арга замыг олжээ.

Xreading.com буюу цахим номын санг суралцагч өөрийн гар утас болон компьютерээ ашиглан англи хэлээр олон зуун сонголт бүхий цахим номын сангаас өөрийн сонирхол хийгээд хэлний түвшинд нийцсэн ном зохиолыг аудио хэлбэрээр сонсох, уншсан номынхоо талаар дасгал ажиллан үгсийн сангаа баяжуулах, хэлний

бусад чадваруудаа зэрэг хөгжүүлэх боломжтой ба суралцагчийн унших үйлийг хязгааргүй дэмжих гол зорилготой. Энэхүү арга суралцагчийн цаасан ном унших сонирхлыг үл хязгаарлах ба уншсан тохиолдолд өөрийн номын түүхэндээ багтаан бүртгүүлж явах боломжтойгоороо давуу талтай. Одоогийн байдлаар энэхүү цахим номын санд нийт хорин хэвлэлийн компанийн 1000 гаруй ном зохиол орсон бөгөөд өмнөх оноос 200 гаруй ном зохиолоор номын сангаа баяжуулсан байна.

Хөнгөн уншлагын аргыг өнөөгийн суралцагсдын сурах хандлага хийгээд шаардлагад нийцүүлж интернетэд суурилсан сургалтын нэг арга болгон ашигласнаар тэдний ном унших сэдэл тэмүүллийг төрүүлэх, уншиж ойлгох

чадвар хийгээд үгсийн санг эрчимтэй баяжуулах боломж бүхий шилдэг арга болохыг олон судлаач нар судалсны нэг нь Кот Т, Миллинер Б нар юм. Тэд Xreading.com цахим номын санг ашигласнаар суралцагсдын ном унших хандлага цаасан хэлбэрээс илүү байсныг тогтоосны сацуу унших үйлийг өдөр тутмын хэвшил болгосон уншигчдын унших хурд өссөнөөс гадна TOEIC-ын шалгалтын оноо дээшилж байсныг өөрсдийн судалгааны ажилдаа нотолсон байна. (Cote Travis, Milliner Brett, 2015)

Доорх хүснэгтээр суралцагчийн хэлний түвшинг “Xreading.com” цахим номын санд хэрхэн тодорхойлсныг харуулав.

Хүснэгт 1 Хөнгөн уншлагын түвшин ба түвшин бүрд унших үгийн тоо

Түвшин	Эхлэн суралцагч /Beginner/	1 (51-100)	2 (101-200)	3 (201-300)
	Анхан /Elementary/	4 (301-400)	5 (401-600)	6 (601-800)
	Анхан дунд /Intermediate/	7 (801-1000)	8 (1001-1250)	9 (1251-1500)
	Анхан дээд /Upper intermediate/	10 (1501-1800)	10 (1501-1800)	12 (2101-2400)
	Ахисан /Advanced/	13 (2401-3000)	14 (3001-3600)	15 (3601-4000)

Эх сурвалж: Xreading.com, 2019

2. Xreading.com цахим номын санг англи хэлний сургалтад нэвтрүүлсэн нь

Цахим номын санг Мандах их сургуульд 2017-2018, 2018-2019 оны хичээлийн жилүүдэд нийт гурван үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа бөгөөд эхний шатыг “Xreading.com” цахим номын санг үүсгэн байгуулагч Паул Голдберг болон бүс нутгийн зохицуулагч Том Коч багш нартай холбогдож, туршилтын нэг сарын хугацаанд арван оюутны эрх бүхий ангийг 2017.12.27-2018.01.27-ны хооронд үүсгэж ажиллуулсан ба цаг хугацааны хувьд хэдий тохиромжгүй байсан хэдий ч /улирлын шалгалт, шинэ жил, оюутны өвлийн амралт/ багш бидний хүлээлтээс давсан эерэг үр дүн гарсан нь цаашид энэ аргыг үргэлжлүүлэх урам зориг болсон.

Туршилтын хугацаанд уншигч бүрийн уншсан номын тоо, номын дундаж түвшин, нийт унших үгийн тоо, уншсан үгийн тоо, тухайн сонгосон номын уншсан хувь, зарцуулсан цаг, нэг минутад уншсан үгийн тоо, сорил асуулгын

дундаж дүн, уншсан номд өгсөн үнэлгээ зэргийг багш нарын зүгээс хянаж, зөвлөгөө өгч ажиллахад технологит суурилсан програмын шийдэл LMS буюу суралцагчийн унших үйлийг хянах системийг шийдэж өгсөн нь багш бидний хувьд давуу талтай байв.

Суралцагчийн хувьд багшийн үүсгэсэн эрхээр нэвтэрч, програмын номын санд байх 1000 гаруй номын сонголтоос өөрсдийн сонирхол, түвшиндээ тохируулан сонгон авч, гар утас болон компьютерээ ашиглан цахимаар, давхар аудио хэлбэрээр сонсож, уншихын зэрэгцээ өөрсдийн унших үйл явцаа багшийн адил хянах боломжтой.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд туршилтын ангид цахим номын санг нэвтрүүлсэн үр дүнг харуулбал:

Хүснэгт 2

Туршилтын ангийн үр дүн

Бүртгэлийн дугаар	Уншлагын түвшин	Уншсан номын тоо	Нийт унших үгийн тоо	Уншсан үгийн тоо	Уншсан хувь	Зарцуулсан цаг	Унших хурд /нэг минутад/	Сорилын дундаж	Уншсан номд өгсөн үнэлгээ
10	3	11	50702	276	77.4	0:08:51	87.6	30	0
9	2	14	10795	10795	100	3:06:00	61.3	90	1
8	3	19	19593	7179	89.5	1:27:37	85.7	40	1
7	3	8	15163	11376	100	1:29:21	129.1	80	0
6	2	8	10182	1276	76.3	0:42:12	38.1	57	5
5	3	6	42039	23161	72.5	4:17:33	121.5	75	3
4	3	5	14734	10059	100	2:11:57	85.8	56	0
3	2	5	25563	2022	68.1	0:28:32	325.6	20	5
2	2	4	1045	1045	100	0:15:15	70.2	70	1
1	2	6	5529	1035	87.5	0:38:51	38.5	47	4
Дундаж	2.5	8.6	19535	6822	87.1	1:28:36	104.3	56.5	2.9
Нийт		86	195345	68224		13			

Эх сурвалж: Судлаачдын тооцоолсноор

Багш бидний зүгээс оюутан бүр долоо хоногт нэг ном, нийт дөрвөн ном унших хүлээлттэй байсан хэдий ч хүснэгтэд харуулснаар нийт 86 ном буюу дунджаар нэг суралцагч 8.6 ном ба хамгийн ихдээ 19 ном уншсан нь цаашид энэхүү аргыг сургалтад нэвтрүүлэх боломжтойг харуулсан болно. Мөн уншлагын түвшинг өөрсдийн сонирхол хийгээд хэлний чадвартаа нийцүүлж ахиулан уншсан байгаа нь сайшаалтай байв. Үзүүлэлт нэг бүрийг цааш тодруулахад нийт 195 мянган үг уншихаас 68 мянган үгийг ойролцоогоор 13 цагт, минутад дунджаар 104 үгийг, уншиж ойлгох сорилын дүн 56%-тайгаар уншсан байна. Туршилтын богино хугацаанд хөнгөн уншлагын аргыг цахим номын санг ашиглан хэрэгжүүлсэн нь оюутнуудын хүсэл сонирхолд нийцсэн, хичээлээс гадуур тэдний чөлөөт цагийг англи хэлний мэдлэгээ дээшлүүлэхэд чиглүүлсэн үр дүнтэй арга болохыг багш бидний зүгээс харж цаашид англи хэлний сургалтад нэвтрүүлэхэд практик ач холбогдолтой болохыг харуулсан юм.

Үүний дараа хоёрдугаар үе шатыг 2018.04.01-2018.10.01-ны хооронд хэрэгжүүлсэн ба үр дүнг харуулбал:

Хүснэгт 3

Хоёр дахь шатны уншлагын үр дүн

Бүр. дугаар	Унш ном	Унш/ үг тоо	Ном/ д/түв	Уншсан цаг (ц:м:с)	Унших х/мин	Сонс/цаг (ц:м:с)	Тооцогсорил	Сорилын дундаж
1	15	3669	2.5	00:37:14	103.7	00:07:54	2	80
2	35	10510	4.2	01:47:43	92.5	00:00:00	9	76
3	13	1258	3.7	00:35:27	38.9	00:15:55	3	93
4	17	1804	3.0	00:15:39	108.5	00:14:14	2	90
5	36	13616	4.8	02:32:33	71.4	01:00:39	6	83
6	18	3909	6.8	00:45:03	83.5	00:00:00	4	90
7	38	16520	9.5	03:39:27	86.5	00:15:58	13	73
8	13	638	2.5	00:09:02	78.2	00:01:13	2	90
9	1	103	1.0	00:03:12	32.2	00:12:46	1	100
10	8	690	4.0	00:21:03	33.9	00:18:32	2	70
11	15	1860	5.0	00:45:15	46.0	00:02:58	3	66
12	8	900	2.3	00:16:54	91.7	00:13:39	3	66
Дундаж	18.1	4623	0:56		6.1	4.16	82	
Нийт	217	554774.1	11:18:		7002	50	984	

Эх сурвалж: Судлаачдын тооцоолсноор

Энэ шатанд нийт арван дөрвөн суралцагч хагас жилийн эрхтэйгээр хамрагдсан боловч хоёр оюутан огт уншаагүй тул үзүүлэлтээс хасаж тооцов. Уг хугацаанд нийт 12 уншигч 217 ном буюу нэг оюутан дунджаар 18 номыг минутад 70 үгтэй уншсан буюу өмнөх шаттай харьцуулахад хурд 30%-аар буурсан, сорилын дундаж 82%-тай буюу нэгдүгээр шатнаас 26%-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа нь тэдний уншлагын хурд удааширсан, ингэснээр уншиж ойлгох чадвар

дээшилж, өмнөх шатнаас туршлагажсан байгааг харуулж байв.

Бүс нутгийн зохицуулагч Том Коч багшийн зөвлөснөөр Кэмбриджийн түвшин тогтоох шалгалтыг хоёрдугаар шатанд уншлага эхлэхийн өмнө авсан ба энэ үр дүнг гуравдугаар шатанд үргэлжлүүлэн хамрагдаж байгаа оюутны үзүүлэлттэй харьцуулсан болно.

Хүснэгт 4

Түвшин тогтоох шалгалт

Үнэлгээний хэсэг	Xreading түвшин-3/315/		Үгсийн сан 25	Сонсгол 20	Кэмбриджийн түвшин
	Уншлагын хурд/мин	Сорилын дундаж	Кэмбриджийн Түвшин Тогтоох Шалгалт		10-11 A2KEY for schools
Уншлагын өмнөх	79	87	8.25	14.75	12-15 A2 KEY for schools
Уншлагын дараах	86	89.1	23	18	16-17 B1Preliminary /PET

Эх сурвалж: Судлаачдын тооцоолсноор (www.cambridgeenglish.org/test-your-english/for-schools/
www.cambridgeenglish.org/test-your-english/young-learners/)

Дээрх хүснэгтээс харахад түвшин тогтоох шалгалтыг тасралтгүй урт хугацаанд уншиж байгаа оюутнуудаас авах нь судалгааны үр дүнг илүү бодитой болоход нөлөөлнө гэж үзэж болохоор ба уг шалгалтын шалгуураар ахисан үзүүлэлт харагдаж байна.

Xreading цахим номын санг хэрэгжүүлэх явцад багш бидэнд хэд хэдэн бэрхшээл тулгарч байснаас энэ шатанд төлбөрийн асуудал хийгээд хэрэгжүүлэх хугацааг оновчтой тооцоолоогүй байв. Эдгээр бэрхшээлүүдийг шийдвэрлэхийн тулд Мандах их сургуулийн ГХТ-ээс зохион байгуулдаг уламжлалт тэмцээнүүдийн төсөвт суулгаж шагналын сангаас түрүүлсэн оюутнуудад тус цахим номын санг хагас жилийн турш үнэгүй

ашиглах эрхийн сертификатаар урамшуулсан нь суралцагсдын талархлыг хүлээсэн мөн тэдний англи хэлний мэдлэгээ чөлөөт цагаараа ахиулах боломж олгосон шинэлэг шийдэл байсан хэдий ч үнэгүй зүйлд хандах хандлага хийгээд зуны амралтын хугацаатай давхацсан зэрэг нь энэ шатанд мэдэгдэхүйц сөрөг нөлөө үзүүлсэн гэж дүгнэж байна.

Сүүлийн буюу гуравдугаар шатны хугацаа дуусаагүй үргэлжилж байна. Энэ шатанд багш оюутнаас бүрдсэн нийт 34 уншигчаас идэвхгүй 11-ийг хасаж уншигч нэг бүрийн үзүүлэлтийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 5

Гурав дахь шатны уншлагын үр дүн

Бүртгэлийн дугаар	Уншсан номын тоо	Уншсан үг/тоо	Номын дундаж түвшин	Уншсан цаг (ц:м:с)	Унших хурд (нэг мин)	Сонссон цаг (ц:м:с)	Сорилын дундаж
1	36	9974	2.80	2:48:29	57.3	0:26:17	69.7
2	18	33280	2.80	19:42:27	27.6	17:59:07	86.7
3	40	18830	4.70	9:23:48	60.4	0:00:00	87.0
4	45	47533	3.70	10:11:18	70.9	11:27:23	76.7
5	8	2458	2.90	23:05:06	77.0	1:01:02	46.7
6	5	5687	5.00	1:52:57	71.4	1:13:18	64.0

7	10	1093	5.20	0:32:03	58.7	0:22:29	35.0
8	18	9240	2.90	2:52:12	57.3	0:18:34	74.4
9	8	5735	3.10	2:09:51	45.4	0:08:18	65.0
10	17	5228	2.00	1:56:28	51.5	0:04:14	67.1
11	15	3361	2.10	1:02:36	54.3	0:51:25	68.6
12	17	8534	3.10	2:00:00	68.9	0:02:18	67.1
13	5	1814	2.00	0:35:04	53.3	0:45:21	48.0
14	17	11204	4.60	1:34:50	98.8	1:12:57	64.7
15	16	9714	2.90	2:17:06	65.4	1:34:34	78.8
16	25	33023	3.70	15:11:39	37.3	65:18:44	95.8
17	8	6771	4.40	1:41:44	59.4	1:22:46	75.0
18	7	3259	5.50	2:18:55	20.9	1:44:46	51.4
19	6	2723	1.80	1:14:18	35.2	0:00:00	86.7
20	12	4989	5.20	1:06:51	73.7	1:17:53	60.0
21	42	85702	4.00	43:07:36	85.1	0:00:00	76.9
22	54	147022	5.00	25:05:06	101.3	16:37:20	86.3
23	17	5755	3	1:29:09	76,0	1:01:05	75.0
Дундаж	19	20127.3	3.58	7:06:09	62	5:25:39	70
Нийт	446	462929		157 ц	1407,1	124:49:51	

Эх сурвалж: Судлаачдын тооцоолсноор

Энэ шатанд тодорхой бус шалтгааны улмаас зарим уншигчдын үр дүн системийн алдаанаас шалтгаалан хянах хэсэгт харагдахгүй саатал гарч байгаа хэдий ч тухайн уншигч бүртэй холбогдож тодруулсан болно.

Xreading.com цахим номын санг ашиглан хөнгөн уншлагын аргыг хэрэгжүүлсэн гурван үе шатыг дараах графикаар харьцуулж харуулав.



Зураг 1 Хэрэгжүүлсэн үе шатуудын харьцуулалт (Эх сурвалж: Судлаачдын тооцоолсноор)

Хүснэгтээс харахад нийт хэрэгжүүлсэн үе шатуудаас дараах үр дүн гарсныг харж болохоор байна. Үүнд:

- хамрах хүрээ: Энэ хугацаанд оюутан болон багш нарын нийт 45 уншигч хамрагдсан бөгөөд төлбөрийн асуудлыг 100%-ийн өөрсдийн санхүүжилтээр шийддэг болсон давуу талтай.
- уншсан номын тоо: Шат ахих бүрд уншсан

болон унших номын тоо нэмэгдсэн ба нийт 966 ба нэг уншигч дунджаар 22 ном уншжээ. Туршилтын шатны уншлагын түвшин 2.5 байсан бол хоёр дахь шатанд 4.1 сүүлийн шатанд 3,6 болж дунджаар 3.4 буюу нэгдүгээр шатнаас 0.9%-иар түвшин ахисан байна.

- зарцуулсан цаг: Мандах их сургуулийн оюутнуудаас авсан судалгаагаар нэг оюутан өдөрт 4-5 цаг түүнээс дээш цагийг цахим орчин, интернетэд өнгөрөөдөг ба / Судалгааны ажил, Багш нарын ЭШХ, 2018 он/ үүнээс нийт 202 цагийг хөнгөн уншлагын аргаар зорилтот хэлээр ном уншиж, сонсон чөлөөт цагаа хэлний мэдлэг, чадвараа хөгжүүлэхэд зарцуулсан байна.

Дээр дурдсан үр дүнгээс гадна үл хэмжигдэхүйц зарим үр дүн гарч байгааг онцлох нь зүйтэй.

- мэдлэг түгээх болон бусдаас суралцах чадвар: Уншигч оюутнуудын дунд зохиосон арга хэмжээнд өөрсдийн уншиж буй арга туршлагаа хуваалцаж, сурч мэдсэн зүйлээ бусадтай нээлттэй илэрхийлж байгаа нь бусад суралцагчдад сэдэл тэмүүлэл, урам зориг өгч байв.
- өөртөө итгэх итгэл, ирээдүйн зорилго чиглэлээ тодорхойлох: Англи хэлээр дэлхийн хэмжээний уран зохиолын болон олон төрлийн ном зохиолыг өөрийн сонголтоор уншиж байгаа нь тэдний сонирхлыг төрүүлээд зогсохгүй ирээдүйн зорилго, хүсэл мөрөөдлөө

илүү өргөн цар хүрээтэй сэтгэх, түүнд тэмүүлэх үүд хаалгуудын нэг нь энэхүү арга болсныг уншигч оюутнуудын өдөрлөгийн илтгэлүүдээс харж болохоор байв./Мандах их сургуулийн оюутнуудад хийсэн сургалт, 2018.02.29/

Хөнгөн уншлагын аргыг дэлхийн олон орны судлаачид сургалтын хөтөлбөртөө

Хүснэгт 6

Стандарт үзүүлэлттэй харьцуулсан үр дүн

Үзүүлэлт	Уншлагын хурд	Өдөрт 20 минут	Долоо хоногт	Нэг жилд	Хэрэгжүүлэх хугацаа	Судлагдсан байдал
Стандарт хэмжээ	80 100 120	1600 2000 2400	8000 10000 12000	224000 280000 336000	14 долоо*2	David&Alan /2014/
Япон	70.3	1406	7030	195,620	14 долоо*2	Burrow's /2012/
Хонг-Конг Вьетнам Монгол	138 161.1 79	2760 3222 1580 632/8	138000 16.111 7900 567	388000 145000 252800 713751/15862	нэг семистр хоёр сар гаруй 16 долоо*2 долоон сар	Lao&Krashen /2000/ Rajan&Jacob /1999/ Мандах их сургууль


Эх сурвалж: Судлаачдын тооцоолсноор

Судлаачдын үзэж байгаагаар уншигч нэг жилд 200,000 мянган үгийг унших боломжтой ба тухайн уншигчийн уншлагын хурдаас шалтгаалан хэрэгжих хугацааг тодорхойлжээ. Дунджаар минутад 80 үг уншвал хичээлийн жилийн хоёр улирлын хугацаанд /Японы их сургуулиудын нэг улирал 14 долоо хоногтой/ хангалттай биелнэ гэж үзсэн байна. Бусад орнуудтай харьцуулахад Монгол оюутнуудын уншлагын хурд минутад 79 буюу дундаж байгаа боловч унших үйлийг өдөр тутмын дадал хэвшил болгоогүйн улмаас стандарт хэмжээнд хүрэхэд хугацаа их шаардагдах болох нь харагдаж байна. Үүнийг уншигч оюутнуудыг идэвхтэй уншихад багш бидний зүгээс хангалттай хөшүүрэг ашиглах боломжгүй байгаатай холбоотой гэж дүгнэж байна.


Хөнгөн уншлагын онолоор суралцагч хичээлийн бус цагаар, өөрт таатай орчинд, түвшиндөө тохирсон хялбар ном зохиолыг өдөрт 20-30 минут уншихыг зөвлөдөг. Тэгвэл энэ дадал уншигч оюутнуудад хэрхэн хэрэгжиж буйг идэвхтэй таван уншигчийн хандалтаар цааш тодруулав.

хэрэгжүүлж, судалгаа хийсэн байдаг. Эдгээр судалгааны ажлуудаас зөвхөн хоёр үр дүнг тодруулбал нэг жилд унших үгийн тоо хамгийн багадаа хэд байх болон минутад унших үгийн тоог Мандах их сургуульд хэрэгжүүлсэн үр дүнтэй харьцуулахыг цааш зорилоо.

Зураг2 Хандалтын дундаж Мандах Их Сургууль:



Зураг3 Дэлхийн дундаж хандалт




(Эх сурвалж: Эх сурвалж: Судлаачдын тооцоолсноор www.statista.com, 2017)

Дээрх графикаас харахад нэг оюутан дунджаар дөрвөн өдрийн давтамжтай уншиж байгаа нь нийт оюутнуудын өдөр тутмын дадал хэвшил суугаагүй, өөрсдийн унших үйлд хариуцлагатай ханддаггүй болохыг


харуулж байна. Энэ нь хөнгөн уншлагын аргыг гадаад хэлний сургалтад ашиглахад тулгардаг хамгийн түгээмэл бэрхшээл бөгөөд шийдвэрлэх арга замын нэг нь суралцагчийн хичээлийн үнэлгээтэй холбох юм. Хөнгөн уншлагын аргыг хэрэгжүүлсэн байдлыг ерөнхийд нь харвал оюутнуудын ном унших сонирхол сул байгааг харуулж байгаа бөгөөд судлаач бид цааш Монгол хүний ном унших хандлагыг /төрлөх болон зорилтот хэлээр/ дэлхийн бусад орнуудтай харьцуулж тодруулахыг зорсон болно.

NOP олон улсын байгууллагаас дэлхийн улс орнуудын ном унших хандлагыг тодруулахаар хийсэн судалгаагаар тус судалгаанд хамрагдагсдын ойролцоогоор гуравны нэг хувь нь өдөр болгон ба долоо хоногт дор хаяж нэг удаа ном уншдаг гэсэн үзүүлэлтээр Хятад, Их Британи, Испани, АНУ, ОХУ туст ус эхний таван байрыг эзэлсэн байна. Мөн Монгол суралцагчдын ном унших идэвх сул байгааг дэлхийн бусад улс орнуудтай харьцуулж харуулав.

Зураг 4 Долоо хоногт ном уншихад зарцуулах хугацаа /цагаар/



Зураг 5 Ном их уншдаг улс орон



(эх сурвалж: www.statista.com, Niall McCarthy, 2016)

Дээрх судалгааны байгууллагын “Дэлхийн ямар улс долоо хоногт хэдэн цагийг ном уншихад зарцуулдаг вэ?” гэсэн судалгаагаар 10:42 минут ном уншдагаараа Энэтхэгчүүд энэ жагсаалтыг тэргүүлж, 9:24 минутаар Тайландууд, 8 цагийг Хятадууд удаалжээ. Харин Монгол улс энэ жагсаалтаас харахад долоо хоногт 3 цагийг ч ном уншихад зориулдаггүй ба Африк, Латин Америк болон Афган, Пакистан зэрэг Дундад Азийн орнуудтай нэг түвшинд буюу дэлхийн дунджаас хол хоцорсон байгааг харж болохоор байна.

Энэ байдалд нөлөөлөх хүчин зүйлийг олон янзаар тайлбарлаж болох бөгөөд зорилтот хэлээр ном уншихын тухайд багш бидний зүгээс

гадаад хэлний сургалтад эрчимт уншлагын аргаас гадна хичээлийн бус цагаар ном уншихад хөтлөх энэхүү аргыг сургалтын хөтөлбөрт тусгах нь зүйтэй гэж үзэж байна. Учир нь ерөнхий англи хэл хөтөлбөрийн хүрээнд Xreading цахим номын санг ашиглахаас гадна мэргэжлийн англи хэл хичээлийн хөтөлбөрийн агуулга бүхий мэргэжлийн ном, зохиолыг уншсанаар сургалтыг баяжуулах, бусад орны соёл хоорондын ялгаанаас суралцах, илүү практик хэрэглээ бий болгох зэрэг өргөн боломж буйг бидэнд харуулж байна. Нөгөө талаар суралцагсад унших соёлд төлөвших, тэднийг сэдэлжүүлэхэд гол хөшүүрэг болно гэж үзэж байна.

Дүгнэлт

Шинэ зууны суралцагч хийгээд технологийн дэвшилд тулгуурласан гадаад хэл заах арга зүйн дэлхийн чиг хандлагад нийцүүлж, англи хэлний сургалтад түүний үр өгөөж болон давуу талуудыг ашиглах боломж багш бидэнд улам бүр нээлттэй болсоор байна. Үүний нэг арга болох унших чадварт чиглэсэн хөнгөн уншлагын аргыг Xreading.com цахим номын санг ашиглан хэрэгжүүлэх боломж билээ. Цаашид энэхүү аргыг гадаад хэлний сургалтад ашиглах талаар дараах дүгнэлтийг хийж байна.

1. Сургалтад хөнгөн уншлагын аргыг нэвтрүүлэх, хөтөлбөрт тусгах
2. Суралцагчдыг идэвхтэй уншихад чиглэсэн аргуудыг ашиглах (жишээ нь үнэлгээтэй холбох)
3. Дэлхийн жишгээс хол хоцорсон байгаа унших үйлд шимтүүлэхэд багшийн зүгээс хөтлөх

Ном зүй

- Chen, C. C. (2013). The Effects of Extensive Reading via E-books on Tertiary Level, EFL Students' Reading attitude, reading comprehension and vocabulary. *Educational technology*.
- Cote Travis, Milliner Brett. (2015). Online extensive reading. *IALLT Journal of Language Learning Technologies*.
- Day, R. B. (1998). Extensive Reading in a second language classroom. *Reading in a foreign language*.
- Day, R. R. (2015). Extending extensive reading. *Reading in a Foreign Language*, 294-301.
- Kelly, L. (2015). 25 centuries of language teaching. *Reading in a Foreign Language*, 294-301.
- Krashen, S. (2014). Extensive Reading in English as Foreign Language by Adolescents and Young Adults. *International Journal of Foreign Language Teaching*.
- Kyung-Sook Cho, S. D. (1994). Acquisition of vocabulary from the Sweet Valley Kids series: Adult ESL acquisition. *Journal of reading*.
- Mason, B. (1997). *Extensive reading in English as a foreign language*.
- Rasinski, T. V. (2006). *Fluency Instruction*. New-York: Guilford Publications.
- Richard, D. (2015). Extensive reading in theory and in practice. *Research Gate*.
- Slatter, T. (2018). Why reading is important.
- West, M. (1955). Learning to read a foreign language and other essays on language teaching (2nd ed). *Learning to Read a Foreign Language*, 1-46.

Extensive reading

Nandintsetseg.Sh, Ariunaa.N,
Mandakh University

Abstract

As the technology is developing rapidly, students are increasingly eager to use their advantages in EFL classrooms. Based on their interests and needs, teachers are increasingly using educational technology in their teaching. This paper intends how we have been implementing one of them called Xreading. com promoting extensive reading at Mandakh University. Over one year period, individual reading engagement in three stages was adopted and data demonstrate that our students started motivating to read in English. Moreover, we aimed to share some outcomes such as their reading process and some figures compared to other countries' learners. Reading in English extensively has not only changed their learning way but also we have found out it provides one of the opportunities for us to develop changing pedagogy for English language teachers.

Keywords

Graded readers, online library, implementation, reading habit